



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар Б/32

Чингис хот

М.Дэлгэрзаяаг ажлаас чөлөөлж,  
ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" 275 дугаар тогтоолын хавсралт, "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн Малчинхүүгийн Дэлгэрзаяаг тус хэлтсийн Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилон ажиллуулах болсон тул 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтний албан тушаалд М.Дэлгэрзаяаг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

3. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Цэцэгсүрэн	Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн
	Т.Бямбадулам	Архив, бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Нярав

4. М.Дэлгэрзаяагийн цалинг ТЗ-5-2 шатлалаар тогтоон үндсэн цалин 680286 /зургаан зуун наян мянга хоёр зуун наян зургаа/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

5. Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг М.Дэлгэрзаяад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР